

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН “ҮДИЙН ХООЛ”-НЫ  
2022 ОНЫ ТӨСВИЙН ЗАРЦУУЛАЛТАД ХИЙСЭН НИЙТИЙН СОНСГОЛЫН  
ТЭМДЭГЛЭЛ

№02

2023 оны 11 Дүгээр сарын 01-ны өдөр

Хүрэмт

Ерөнхий боловсролын сургуулийн “Үдийн хоол”-ны 2022 оны төсвийн зарцуулалтад төсвийн хяналтын сонсголыг 2023 оны 11 дүгээр сарын 01-ны өдрийн 12<sup>20</sup> цагт сумын ИТХ-ын ажлын өрөөнд эхлэв.

Нийтийн сонсгол даргалагчаар ИТХурлын төлөөлөгч Ч.Батжаргал, дуудагдсан албан тушаалтан сумын Засаг дарга З.Түмэндэмбэрэл, ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн сургалтын менежер М.Нарнагэрэл, нягтлан бодогч Б.Болортуяа, нярав Алтаннэмэх, тогооч Ш.Тогоотогтох. Оролцогчоор ИТХ-ын төлөөлөгч Н.Галбадрах, ИТХ-ын төлөөлөгч П.Лхагвадорж, ИТХ-ын төлөөлөгч Т.Бямбасүрэн, Заяадаваа ЕБСургуулийн дотуур байрны жижүүр, Б.Саруулбаяр ниигмийн даатгалын байцаагч, Т.Лхагважав Соёлын төвийн дарга, Г.Долгорболоож Соёлын төвийн нярав, С.Энхмаа шуудан холбооны эрхлэгч, Д.Оюунжаргал ИТХ-ын төлөөлөгч, С.Лхагвадорж хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн, Б.Батбаатар 3-р багийн Засаг дарга, ажиглагчаар Г.Энхцэцэг Жижиг дунд үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтэн, Д.Должинсүрэн Нягтлан бодогч, О.Цэрэндагва Хүрэмт багийн иргэн. ИТХ-ын ажлын албанаас ИТХ-ын нарийн бичгийн дарга Ш.Элбэгжаргал, ИТХурлын ажлын албаны мэргэжилтэн Л.Золжаргал нар оролцов.

Сонсгол даргалагч ИТХ-ын төлөөлөгч Ч.Батжаргал-Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Ерөнхий боловсролын сургуулийн “Үдийн хоол”-ны 2022 оны төсвийн зарцуулалтад төсвийн хяналтын сонсгол үүгээр эхэлж байна. Сонсгол удирдах дараалал, баримтлах дэг танилцуулъя. /Материал хавсаргав/. Дуудагдсан албан тушаалтанд ЕБСургуулийн захирал Ц.Хоролмаа тасалсан байна. ИТХ-ын ажлын албанд хүндэтгэн үзэх шалтгаанаа мэдэгдсэн үү.

ИТХ-ын нарийн бичгийн дарга Ш.Элбэгжаргал-Хяналтын сонсголд оролцох боломжгүй гэсэн шалтгаанаа мэдэгдээгүй.

Сонсгол даргалагч ИТХ-ын төлөөлөгч Ч.Батжаргал-ЕБСургуулийн захирал Ц.Хоролмаа хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр сонсгол тасалсан учир нийтийн сонсголын хуулийн дагуу арга хэмжээ авахыг Засаг дарга З.Түмэндэмбэрэлд үүрэг болгохыг үүгээр мэдэгдэж байна. ЕБСургуулийн Үдийн хоолны төсвийн зарцуулалтын тайланг дуудагдсан албан тушаалтан ЕБСургуулийн нягтлан Б.Болортуяа танилцуулна. /Материал хавсаргав/

Сонсгол даргалагч ИТХ-ын төлөөлөгч Ч.Батжаргал- Үдийн хоол"-ны 2022 оны төсвийн зарцуулалтад төсвийн тайланг сонслоо. Үдийн хоол"-ны 2022 оны төсвийн зарцуулалттай холбоотой асуулт асуух оролцогчид гараа өргөнө үү? Оролцогч Н.Галбадрах та асуултаа асууна уу?

Оролцогч ИТХ-ын төлөөлөгч Галбадрах-Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе.1. ЕБСургуулийн үдийн хоол"-ны 2022 оны төсвийн зарцуулалтын нийтийн сонсгол хоёр дахь удаагаа болж байна. Эхний удаа дуудагдсан албан тушаалтан нягтлан Б. Болортуяа ирээгүй учраас хойшлогдсон. Өнөөдөр захирал нь алга. Ард иргэдийн мэдэх эрхийг нь хягаарлаад байна уу? Мэдээллээ яагаад нээлттэй өгөхгүй байна вэ? 2. Хүүхдүүдийн хоолны гол бүтээгдэхүүн мах нь өмхийрсөн байна гэсэн. Үнэн үү? Үнэн бол тайлбар өгөөч. Нотлогдсон уу? Энэ асуудлаар хавар хичээл тарах үе таарсан байсан учраас хойноос нь хөөцөлдөөгүй Хэн буруутай ажилтандаа хариуцлага тооцсон уу? Ер нь сургуулийн үдийн хоолонд хэн хяналт тавьж байна. Харилцан ярилцах хэрэгтэй байна. Эрх мэдэлтэнтэнд нь байна уу? Доод албан тушаалтанд нь байна уу? Гэдэг асуудал байна. Махтай холбоотой асуудалаа яаж шийдсэн бэ? Тодорхой хариулт сонсий.Энэ 2 асуултандаа хариулт авъя.

Сонсгол даргалагч ИТХ-ын төлөөлөгч Ч.Батжаргал-ЕБСургуулийн бага ангийн сургалтын менежер М.Нарангэрэл хариулна.

ЕБСургуулийн бага ангийн сургалтын менежер М.Нарангэрэл-Өөрийнхөө хэмжээнд хариулт хэлий. Хавар 4 дүгээр сард ИТХ-аас ажлын хэсэг хөндлөнгийн хяналт хийхэд муудсан 85 кг мах илэрсэн. Шинжилгээ, актын дагуу утгалд оруулсан. Зоорьны хадгалатаас мах муудсан. Сургуульд Үдийн хоолыг хариуцсан хоол зүйч, эмчийн орон тоо байдаг. Манай сургуульд байдаггүй. Ерөнхий үйл ажиллагааг би хариуцдаг. Төсөв мөнгөнд ороцдоггүй.

Оролцогч ИТХ-ын төлөөлөгч Н.Галбадрах-ЕБСургуулийн нягтлан бодогч Б.Болортуяагаас асууя төсөвт учирсан хохиролоо яаж барагдуулсан бэ?

ЕБСургуулийн нягтлан бодогч Б.Болортуяа-2023 оны 04 сард ИТХ-аас хөндлөнгийн хяналт хийхэд гарсан зөрчил. Хохиролыг төлүүлсэн зүйл байхгүй.

Оролцогч ИТХ-ын төлөөлөгч Н.Галбадрах-Хэн буруутайг нь тогтоогоод төлбөрийг нь барагдуулсан уу?

ЕБС-ын нягтлан бодогч Б.Болортуяа-Хэн буруутайг би мэдэхгүй. Муудсан махны хувьд зоорьны хадгалалтаас болсон. Өвөл махны үнэ кг нь 7500 төгрөг байхад авсан. Хавар үнэ орчихдог. Хэн буруутай албан хаагчид нь захирал хариуцалга тооцоно. Би хариуцлга тооцдог албан тушаалтан биш.

Оролцогч ИТХ-ын төлөөлөгч Н.Галбадрах-ЕБСургууль алдаан дээрээ дүгнэлт хийж алдаагаа засаагүй байна.

ЕБСургуулийн нярав Д.Алтаннэмэх-11 сарын сүүлээр нэг зуун арван хэдэн кг мах бэлтгэлийн газраас 11.000 төгрөгөөр нөөцөлсөн байсан. Ажлынхаа шугмаар мах авч нөөцөлсөн. Манайх 3 хөлөддөгчтэй. Авсан махаа зоориндоо гялгар уутанд боогоод хадгалсан. Хавар дулаан ороод нар туссан хэсгийн махны өнгөн хэсэг муудсан байсан. Зоорны хажуу талд нар тусдаг. Тэр хэсгийн мах ИТХ-ын хурлаас хяналт хийхэд өнгөн хэсэг нь муудсан 85 кг мах байсан. Аймгийн мэргэжлийн хяналтын газарт муудсан махны дээжээ явуулаад шинжлүүлэхэд хүнсэнд хэрэглэж болохгүй гэсэн дүгнэлт гарсан. Би хариуцлгаа хүлээнэ ээ. Сургуулийн дотоод хяналтын хурал

хуралдаагүй. Хуралдаад шийдвэр гархад хариуцалгаа хүлээнэ ээ. Төсвийн зарцуулалт дээр мөнгө үлдэхээр нь татуулж байхаар гээд махаа авсан байсан. Миний алдаа дутагдлаас болж мах муудсан. Нар үзсэн хэсгийн мах өнгөн хэсэг хадгалалт хамгаалтын горимоо алдсан.

Оролцогч ИТХ-ын төлөөлөгч Д.Оюунжаргал-Энд хүрэлцэн ирсэн та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. ЕБСургуулийн үдийн хоолонд хөндлөнгийн хяналтыг жилд хэдэн удаа тавидаг вэ? Энэ нийтийн сонсголын зарыг хэд хонгийн өмнө хүргэсэн бэ? ИТХ-ын албаны мэргэжилтэн Золжаргалаа хэзээ зараа хүргэсэн бэ? Захирал яаж хүлээж авсан бэ? Хавар Хяналтаар явахад хоолны цэс гараагүй батлагдаагүй байсан. Үдийн хоолноос амталгаа хийхэд хоолны махнаас өмхийрсөн амт амтагдаад байсан. Хүүхдүүдэд яагаад ийм махаар хоол хийж өгч байгаа юм бэ? Өөрийнхөө хүүдүүдэд үнэр орсон махаар хоол хийж өгөх үү? Хувийн зүгээс нэг зүйл хэлчихий. Хяналт тавиад орсны дараа эргээд миний хүүхдийг дарамталдаг. Сургууль дээр нэг орхоор нэгийгээ муулсан, дотооддоо зөрчилтэй байдаг. Ер нь ЕБСургуулийн зүгээс ИТХ-ыг үл хүндэтгэсэн шинжтэй байдаг. Хяналт хийгээд орсны дараа Элбэгжаргал, Оюунжаргал 2 хэзээ ийм байсын гэх мэтээр араас дандаа яриа гаргадаг. Хариуцсан ажилдаа анхааралтай ажилмаар байна. Захирал өөрийнхөө эрүүл мэндэд анхаарал тавьдаг мөртлөө, хүний хүүхдүүдэд өмхийрсөн махаар хоол хийж өгнө гэдэг байж болохгүй асуудал шүү.

Сонсгол даргалагч ИТХ-ын төлөөлөгч Ч.Батжаргал-Энэ асуулт дээр ЕБСургуулийн бага ангийн сургалтын менежер М.Нарангэрэл хариулт хэлнэ.

Бага ангийн сургалтын менежер М.Нарангэрэл-Эцэг эхийн зөвлөлөөс хөндлөнгийн хяналтлыг 5 хүний бүрэлдэхүүнтэй томилсон. Хөндлөнгийн шалгалтаар гарсан зөрчил байвал дүгнэлтээ гаргаад тухайн зөрчилөө арилгаад явдаг. Хөндлөнгийн хяналт 2 удаа хийсэн. Үр дүнгийн дагуу ажил зохион байгуулаад явдаг. Жишээ нь ангийн багш ангидаа хоолоо өгдөг байсан, үүн дээр хяналтын зөвлөлөөс сургуулийн гал тогоогндоо сурагчид өдөрт 2 удаа хоололдог болсон. Тогооч хүүхдийн порцыг аяглаж өгөхөд хялбар болсон. Чанаргүй хоол хүнсээр үйлчилдэггүй. Хүүхдүүдийн сэтгэл ханамжаас харагдана. Хоолны цэсээ сар, 7 хонгоор гаргаж захиралаар батлуулаад явдаг. Үдийн хоолонд ач холбогдол өгч ажилдаг. Хоолны нэр төрөл, өдөрт гасан хоолны мэдээллээ цахим систем дээр бүртгэгэдэг. Хоолны дээжээ авч хадгалсан дээр хөндлөнгийн хяналт тавина. Үдийн хоолны журмандаа байдаг. Эрүүл мэндийн чиглэлээр сургалт зохион байгуулдаг. Хүлээсэн үүрэгтэй. Сард 2-3 удаа хөндлөнгийн хяналт тавих нь үдийн хоол олгох журмандаа байдаг. Хоолны цэсэн дээрээ ажлын хэсэг 7 хоног ажиллсан. Тогоочийн өдөрт авсан дээжнээс эцэг, эхийн төлөөлөлөөс санал асуулга авдаг. Хөндлөнгийн хяналт жижиг зүйл дээр анхаарал хандуудлаг юм шиг санагдсан.

Сонсгол даргалагч Ч.Батжаргал-ИТХ-ын ажлын албаны мэргэжилтэн Л.Золжаргал тайлбар хийнэ.

ИТХ-ын мэргэжилтэн Л.Золжаргал-ИТХ-ын ажлын албаны зүгээс нийтийн сонсголын хуулийн дагуу 2023 он 10 дугаар сарын 19-ны өдөр Сонсголд заавал оролцох тухай албан бичгийг ЕБС-ын захирал Ц.Хоролмаанд хүргэж өгөхөд 10-р сарын 25-наас 11-р сарын 14 хүртэл ээлжийн амралтаа биеэр эдэлнэ гэсэн хариу өгөөд албан

бичигтэй танилцаагүй нийтийн сонсголд оролцохгүй гэсэн тайлбар, гарын үсгээ зурж баталгаажуулж өгсөн.

Сонсгол даргалагч ИТХ-ын төлөөлөгч Ч.Батжаргал-Оролцогч Т.Лхагважав асуултаа асуу.

Оролцогч Т.Лхагважав-Төсвийн зарцуулалт дээрээ нэмэлт тайлбар хийгээч.Нэг бүрчлэн.

ЕБСургуулийн нягтлан бодогч Б.Болортуяа-Төсвийн зарцуулалт дээрээ нэмэлт тайлбар хийв./Материал хавсаргав/

Сонсгол даргалагч ИТХ-ын төлөөлөгч Ч.Батжаргал-Асуулт асуух өөр оролцогч байна уу? ИТХ-ын нарийн бичгийн дарга Ш.Элбэгжаргал асуултаа асууя.

ИТХ-ын нарийн бичгийн дарга Ш.Элбэгжаргал-Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. ЕБСургууль дээр хавар 04 дүгээр сард ИТХ-ын зүгээс хяналт хийх эрхийнхээ дагуу хөндлөнгийн хяналт хийсэн. Хүүхдийн эрүүл мэндтэй холбоотой асуудал учраас өөрсдийгөө өмөөрөх нь учир дутагдалтай байна. Сургуулийн үдийн хоолонд хөндлөнгийн хяналтын үйл ажиллагаанд хяналт хийсэн ажлын тайланг танилцуулав. /Материал хавсаргав/

Сонсгол даргалагч ИТХ-ын төлөөлөгч Ч.Батжаргал-Санал хэлэх оролцогчид байна уу? Оролцогч ИТХ-ын төлөөлөгч Т.Бямбасүрэн, ИТХ-ын төлөөлөгч Галбадрах, ИТХ-ын төлөөлөгч П.Лхагвадорж саналаа хэлээд явъя.

ИТХ-ын төлөөлөгч П.Лхагвадорж-Энэ нийтийн сонсгол хавар хийсэн байх ёстой байсан. Сонсголд нягтлан бодогч Б.Болортуяа ирээгүйгээс хойшилсон. ЕБСургууль хүнд сурталтай байна. Хоол гэдэг хүний хамгийн эхний хэрэгцээ. Гэтэл ЕБСургуулиас 4 хүн орж ирсчихээд 4 өөр зүйл яриад байх юм. Хадгалалт дээрээ анхаарч ажиллмаар байна. Суманд хөргүүр ажлуулна гээд сум хөгжүүлэх сангаас зээл авсан иргэн ч байгаа. Орон нутгийн хөгжлийн сангийн 20 сая төгрөгний төсвөөр хийгдсэн 20 тонны зоорь ч байгаа. Сумандаа байгаа хөргүүрээ ашиглаж болдоггүй юм уу? Нар тусдаг зоорь гэж сонсоогүй юм байна.

Оролцогч ИТХ-ын төлөөлөгч Т.Бямбасүрэн-Тайлбар мэдээлэлтэй танилцлаа, сонслоо. Дүгнэлтээс гарсан зөрчлийг арилгах ёстой. Албан ёсны бичиг баримтын тал дээр баримт бичгээ цэгцлэ. Муугаар хэлэхэд хүүхдийн гэдэс өвдөхөд хоолны дээжнээс үү гаднаас бохирдсон уу гэдэг нь гарж ирнэ. Анхан шатны баримт бичгийн ямар нэг эрсдлээс аварч үлдэнэ.

Оролцогч ИТХ-ын төлөөлөгч Н.Галбадрах-Өнгөрсөн хоолны асуудал боловч гаргасан алдаагаа зассан дүгнэлт байх ёстой гэж бодсон. Махыг удаан хадгалж болдог юм уу? Хоолны дээжээ хадгалах нь зөв өө. Төр засаг хариуцалга тооцохгүй байгаатай холбоотой юм уу? Та бүхний ажил энэ махны зөрчлөөс яаж хийдэг нь харагдаж байна. Хариуцалгыг нь хэнээс нэхэх вэ? Өөрсдийгөө хамгаалсан зүйл ярьцгаагаад байна. 4 өөр юм яриад байх юм.

Дуудагдсан албан тушаалтан М.Нарангэрэл-Хяналтын мөрөөр хийсэн тайланг сая сонслоо. Сонсголтой холбоотой асуудалаа л ярих юм байна гэж бодсон. Үйл ажиллагааны талаар болоод явчихлаа. Хөндлөнгийн хяналтаас шалгах зүйлээ л шалгах хэргэтэй. 09 сард хөндлөнгийн хяналт хийсэн. Тайланг нь харж болно. 4 өөр зүйл ярилаа гэдэгт санал нийлэхгүй байна.

Дуудагдсан албан тушаалтан Б.Болортуяа-12 сард мах нөөцлөхөд махны үнэ нэг өөр, хавар мах авхад өөр өөр байдаг. Зах зээлийн үнээс хамгийн хямдыг нь авдаг. Хүний алдаа дутагдалыг олж хардаг юм бэ?

Сонсгол даргалагч ИТХ-ын төлөөлөгч Ч.Батжаргал-Асуулт, санлаа авч дууслаа. Дүгнэлт хийх оролцогч байна уу? Оролцогч ИТХ-ын төлөөлөгч Н.Галбадрах, оролцогч

ИТХ-ын төлөөлөгч Д.Оюунжаргал, ороцогч ИТХ-ын төлөөлөгч Т.Бямбасүрэн дүгнэлтээ хэлээд явъя.

Оролцогч ИТХ-ын төлөөлөгч Н.Галбадрах-Энэ ямар шүүх хурлын танхим биш. Та нар мэдээлэл өгөх шаардлагатай хүмүүс. Та бүхэн ажлаа сайн хийсэн байхаа. Маргалдах гэж цуглаагүй. Биеэ өмөөрөөд байгаа нь харамсалтай.

Оролцогч ИТХ-ын төлөөлөгч Д.Оюунжаргал-Зоорио засварласан уу? Мах хадгалах хөлдөөгчөө нэмээч. Аяга угаагчаа нэмээч. Алдаа дутагдалаа мэдээд засаад ажиллана биз.

Оролцогч ИТХ-ын төлөөлөгч Т.Бямбасүрэн-Нилээд сонслоо. Гол нь ИТХ-аас хяналт шалгалт хийнэ гэдэг хүний мууг үзэх дээ биш. Олгой хагравч тогоондоо гэдэг алдаагаа ухамсарлаад ажилаарай. Хяналтын тайлан очоогүй гэж ойлголлоо.

ИТХ-ын нарийн бичгийн дарга Ш.Элбэгжаргал-Хүүхдийн хоолтой асуудал дээр ЕБСургууль хяналт хийхэд энэ алдаанууд дандаа давтагддаг. 2022 онд хяналт тавиаагүй. ИТХ-ыг сургуулийн зүгээс хүний муу үздэг гэсэн ойлголттой байдаг. Хамт олны хурал дээр нь хяналт хийсэн тайлангаа танилцуулна гэхэд хойшлогдсоор байгаад өдий хүрсэн. ИТХурал гэдэг иргэдээ төлөөлдөг албан газар. Сургуульд хариутай албан бичиг өгдөг, хариу өгдөггүй.

Сонсгол даргалагч ИТХ-ын төлөөлөгч Ч.Батжаргал-Энэ удаагийн нийтийн сонсгол хуулийн хүрээнд хийгдлээ. Заавал оролцох албан тушаалтан хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй. Ямар хариуцлага тооцсон талаараа Засаг дарга З.Түмэндэмбэрэл та хариу өгөөрөй. Үдийн хоол"-ны 2022 оны төсвийн зарцуулалтад тайлан, мэдээ өгсөн та бүхэндээ баярлалаа. Нийтийн сонсгол албан ёсоор хаалаа.

Нийтийн сонсгол 14 цаг 18 минутад өндөрлөв.

ТЭМДЭГЛЭЛ ХЯНАСАН

ИТХ-ЫН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Ш.ЭЛБЭГЖАРГАЛ

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН

ИТХ-ЫН АЖЛЫН АЛБАНЫ МЭРГЭЖИЛТЭН А.Золжаргал.ЗОЛЖАРГАЛ